



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

15 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /96/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Т.Болормаа
Утас: 70350757 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 60
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН 15 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
М.ГАЛБААТАР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн 15 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн 15 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>89,431,828.07</u>	<u>106,190,489.20</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,000.00	6,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,000.00	6,000.00
3121	Төгрөг	6,000.00	6,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	6,000.00	6,000.00
33	АВЛАГА	12,600.00	5,398,890.91
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	12,600.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	5,398,890.91
35	БАРАА МАТЕРИАЛ	89,413,228.07	100,785,598.29
351	Түүхий эд материал	44,279,499.05	49,081,720.71
35110	Тусгай зориулалттай материал	41,248,209.05	47,859,530.71
35130	Эм боох материал	3,031,290.00	1,222,190.00
354	Хангамжийн материал	45,133,729.02	51,703,877.58
35410	Бичиг хэргийн материал	1,217,500.00	1,542,350.00
35420	Аж ахуйн материал	2,485,610.00	1,185,700.00
35430	Сэлбэг хэрэгсэл	165,500.00	1,244,500.00
35470	Бусад хангамжийн материал	41,265,119.02	47,731,327.58
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,065,864,029.25</u>	<u>3,005,078,749.40</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,065,864,029.25	3,005,078,749.40
392	Биет хөрөнгө	2,590,089,029.19	2,529,433,749.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,589,341,245.66	2,589,341,245.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	(96,390,315.52)	(144,932,695.48)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	153,305,232.00	160,391,345.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(138,698,700.51)	(145,049,335.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	144,942,694.66	145,545,354.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(62,411,127.10)	(75,862,164.93)
393	Биет бус хөрөнгө	475,775,000.06	475,645,000.10
39301	Програм хангамж	1,330,000.00	650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(874,999.94)	(324,999.90)
39303	Бусад биет бус хөрөнгө	475,320,000.00	475,320,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,155,295,857.32</u>	<u>3,111,269,238.60</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,905,150.60</u>	<u>4,905,150.60</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,905,150.60	4,905,150.60
413	Өглөг	4,905,150.60	4,905,150.60
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,751,748.60	4,751,748.60
4136	Бусад өглөг	153,402.00	153,402.00
41361	Байгууллагад төлөх өглөг	153,402.00	153,402.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,150,390,706.72</u>	<u>3,106,364,088.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,150,390,706.72	3,106,364,088.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	505,888,257.16	505,888,257.16
512	Хуримтлагдсан үр дүн	1,717,956,376.92	1,673,929,758.20
51210	Өмнөх үеийн үр дүн	1,717,956,376.92	1,717,956,376.92

51220	Тайлант үеийн үр дүн	-	(44,026,618.72)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	926,546,072.64	926,546,072.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,155,295,857.32</u>	<u>3,111,269,238.60</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,367,600,241.96	1,458,388,082.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,075,289.70	21,952,691.22
120	Нийтлэг татварын бус орлого	30,075,289.70	21,952,691.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,318,318.70	21,952,691.22
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,739,322.00	5,029,388.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,578,996.70	-
120009	Бусад орлого	756,971.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө		6,935,413.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материалаал		9,987,890.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,337,524,952.26	1,436,435,390.91
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,226,824,152.26	1,288,890,200.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	38,653,152.26	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,188,171,000.00	1,288,890,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	36,700,190.91
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	17,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,417,190.91
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	7,283,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	110,700,800.00	110,845,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	110,700,800.00	110,845,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,418,218,033.13	1,502,000,132.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,418,218,033.13	1,502,000,132.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,296,094,471.79	1,360,931,045.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	997,528,286.00	1,047,714,984.13
210101	Үндсэн цалин	822,759,685.00	655,547,313.87
210102	Нэмэгдэл	110,791,943.00	306,014,692.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,405,676.00	3,519,517.00
210104	Урамшуулал	59,570,982.00	82,633,461.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,188,320.31	139,098,492.44
210201	Тэтгэврийн даатгал	87,496,862.18	97,848,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,356,956.40	10,476,607.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,987,713.38	8,218,412.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,931,278.43	2,050,470.26

15 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	19,415,509.92	20,504,102.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,520,202.08	51,524,869.77
210301	Гэрэл, цахилгаан	11,127,338.13	12,256,272.40
210302	Түлш, халаалт	22,632,418.96	22,930,808.03
210303	Цэвэр, бохир ус	6,760,444.99	16,337,789.34
2104	Хангамж, бараа материалын зардал	26,125,747.78	16,752,175.00
210401	Бичиг хэрэг	1,420,650.00	4,530,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,385,000.00	1,692,065.00
210404	Ном, хэвлэл	248,400.00	708,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,567,982.00	3,164,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,931,730.00	6,657,510.00
210408	Бараа материал акталсны зардал	13,571,985.78	-
2105	Нормативт зардал	10,612,230.00	1,870,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,207,530.00	854,100.00
210502	Хоол, хүнс	7,675,200.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,729,500.00	1,016,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,096,900.00	20,827,900.00
210604	Урсгал засвар	1,096,900.00	20,827,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,000.00	5,534,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	5,534,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,014,785.62	77,607,324.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	932,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,944,715.00	7,659,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	86,070,070.62	69,015,824.28
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	122,123,561.34	141,069,086.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,811,500.00	71,792,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,251,500.00	69,872,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,560,000.00	1,920,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	69,373,597.92	56,102,330.23
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,373,597.92	56,102,330.23
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,938,463.42	13,174,056.43
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,938,463.42	13,174,056.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(50,617,791.17)	(43,612,050.15)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	414,568.67
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	414,568.67
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(414,568.67)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(50,617,791.17)	(44,026,618.82)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,888,257.16	926,546,072.64	1,761,653,317.68	3,194,087,647.48
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	505,888,257.16	926,546,072.64	1,761,653,317.68	3,194,087,647.48
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(43,696,940.76)	(43,696,940.76)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,888,257.16	926,546,072.64	1,717,956,376.92	3,150,390,706.72
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	505,888,257.16	926,546,072.64	1,717,956,376.92	3,150,390,706.72
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	505,888,257.16	926,546,072.64	1,717,956,376.92	3,150,390,706.72
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(44,026,618.72)	(44,026,618.72)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,888,257.16	926,546,072.64	1,673,929,758.20	3,106,364,088.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,341,812,723.00	1,457,277,178.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,496,293.00	5,029,388.00
120	Нийтлэг татварын бус орлого	17,496,293.00	5,029,388.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,739,322.00	5,029,388.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,739,322.00	5,029,388.00
120009	Бусад орлого	756,971.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,324,316,430.00	1,452,247,790.91
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,188,171,000.00	1,288,890,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,188,171,000.00	1,288,890,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	36,700,190.91
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	17,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,417,190.91
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	7,283,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	110,700,800.00	110,845,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	110,700,800.00	110,845,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	25,444,630.00	15,812,400.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	25,444,630.00	15,812,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,342,005,752.00	1,455,567,478.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,342,005,752.00	1,455,567,478.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,194,437,560.66	1,293,287,101.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	997,525,664.59	1,047,714,984.13
210101	Үндсэн цалин	602,341,125.28	655,547,313.87
210102	Нэмэгдэл	312,269,588.13	306,014,692.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,267,600.00	3,519,517.00
210104	Урамшуулал	77,647,351.18	82,633,461.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,226,976.99	139,085,892.44
210201	Тэтгэврийн даатгал	87,490,400.00	97,836,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,952,000.00	10,476,607.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,890,076.99	8,218,412.20
210204	Ажилгүйдлийн даатгал	1,990,400.00	2,050,470.26
210205	Эрүүл мэндийн даатгал	19,904,100.00	20,504,102.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,520,202.08	51,524,869.77
210301	Гэрэл, цахилгаан	11,127,338.13	12,256,272.40
210302	Түлш, халаалт	22,632,418.96	22,930,808.03
210303	Цэвэр, бохир ус	6,760,444.99	16,337,789.34
2104	Хангамж, бараа материалын зардал	17,705,922.00	12,032,815.00
210401	Бичиг хэрэг	781,700.00	1,833,250.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,384,000.00	1,692,065.00
210404	Ном, хэвлэл	701,400.00	2,194,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,665,322.00	1,148,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,173,500.00	5,164,600.00
2105	Нормативт зардал	1,897,880.00	2,429,540.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	448,380.00	889,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,449,500.00	1,540,440.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	807,000.00	21,917,900.00
210604	Урсгал засвар	807,000.00	21,917,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,008,000.00	5,534,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	5,534,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,745,915.00	13,046,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	469,000.00	988,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,276,915.00	12,058,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	147,568,191.34	162,280,377.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,256,130.00	87,605,100.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	25,444,630.00	15,812,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,251,500.00	69,872,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,560,000.00	1,920,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	69,373,597.92	56,102,330.23
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	69,373,597.92	56,102,330.23
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,938,463.42	18,572,947.34
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,938,463.42	18,572,947.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(193,029.00)	1,709,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,709,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,709,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,709,700.00
222001	Тоног төхөөрөмж		1,709,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(1,709,700.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(193,029.00)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		6,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,000.00	6,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн 15 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Болормаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн 15 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн 15 дугаар сургууль нь ерөнхий боловсролын мэдлэг олгох үйл ажиллагааны хүрээнд бие даан сурах арга барилтай, зөв харилцаа хандлагатай, байгальд ээлтэй, эрүүл чийрэг хүүхэд болгон төлөвшүүлэх зорилгын хүрээнд:

1. Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжин судлагдахуун нэг бүрээр сурагчдад бие даан сурах арга барилыг эзэмшүүлэх, сурлагын хоцрогдлыг багасгах.

2. Багш, ажиллагсад ёс зүйг эрхэмлэн үлгэрлэн манлайлж, суралцагчдад зөв харилцаа хандлагыг хэвшүүлэх.

3. Олон улсын эко сургууль хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, сургалтын орчин, чанарыг сайжруулах.

4. Хүүхдийн бүтээлч санаачилгыг дэмжин, танхимаар болон цахимаар хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулж, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх

5. Сургалтын үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн дэмжлэг оролцоог нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдөр өөрчлөлт орсон.
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн 15 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 1,458,388.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 21,875.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 16,406.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн 15 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44,026.7 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6.0	6.0	-
Авлага	12.6	5,398.9	5,386.3
Бараа материал	89,413.2	100,785.6	11,372.4
Үндсэн хөрөнгө	3,065,864.0	3,005,078.7	-60,785.3
Нийт хөрөнгө	3,155,295.9	3,111,269.2	-44,026.7
Өр төлбөр	4,905.2	4,905.2	-

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,150,390.7	3,106,364.1	-44,026.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,155,295.9	3,111,269.2	-44,026.7

Бараа материалын данс 100,785.6 мянган төгрөг болж 11,372.4 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалд нийт 6,761.3 мянган төгрөг, бусад хангамжийн бараа материал 4,980.2 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,005,078.7 мянган төгрөг болж 60,785.3 мянган төгрөгөөр буурсан нь 8,645.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант оны хуримтлагдсан элэгдлийн 69,015.8 мянган төгрөгийн зардал нэмж бүртгэсэнтэй холбоотой байна.

Орхон аймгийн 15 дугаар сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 90,787.8 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар өссөн, нийт зардал өмнөх оноос 83,782.1 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн 15 дугаар сургууль нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,472,176.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,472,176.2 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 106,194.0 мянган төгрөгөөр бууруулан 1,365,982.2 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 1 удаа тодотгол хийж 37,629.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,403,611.2 мянган төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн ерөнхий боловсролын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 1,288,890.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, орон нутгийн төсвөөс 110,845.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 5,029.4 мянган төгрөг, нийт 1,404,764.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,335,488.2 мянган төгрөгийг зарцуулж, 69,276.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,335,488.2 мянган төгрөг буюу 95.15 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 10,829.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 56,102.3 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 1,107.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулж, хэмнэлт үүсгэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Боловсролын газраас 12,417.2 мянган төгрөгийн хөтөлбөрийн санхүүжилт, Байгаль орчны мэдээлэл сургалтын төвөөс төслийн санхүүжилт 17,000.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7,283.0 мянган төгрөг нийт 36,700.2 мянган төгрөгийн санхүүжилт нэмэлт дансаар орсон байна.

Гүйцэтгэлээр хангамжийн бараа материал 2,151.5 мянга, урсгал завсрын зардалд 18,700.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 3,700.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 5,040.0 мянган төгрөг нийт 31,301.3 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 5,398.9 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Орхон аймгийн 15 дугаар сургууль нь 2021 онд нийт 1,907,007.9 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 1,907,007.9 мянган төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль

тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.3-д “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, 4.4-д “Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө”, 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”. 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, ЗГ-ын 382 дугаар тогтоолын хавсралт 2-ын 3 дах заалт, Засгийн газрын 43 дугаар тогтоолын шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14,899.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,079.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,067.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 6,752.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Багаж техник хэрэгслийн зардлаас 1,079.7 мянган төгрөгийн принтерүүд худалдан авсныг багаж техник хэрэгслийн зардалд буруу тайлагнасныг мөнгөн гүйлгээний тайланд залруулсан.

4.3 Албан шаардлага

1. Тусгай зориулалтын бараа материалын дансанд модон ширээ сандал, чанга яригч, усны аппарат, хүлэмж, спикер зэрэг үндсэн хөрөнгийн шинж чанар агуулсан 5,666.0 мянган төгрөгийн 12 ширхэг зүйлс бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 4.1.3-д “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, 4.4-д “Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө”, УСНББОУС 17-д үндсэн хөрөнгө гэдэг нь “Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн шинж чанар агуулсан 5,666.0 мянган төгрөгийн 12 ширхэг тусгай зориулалтын бараа материалын дансанд бүртгэлтэй байгаа материалыг нэр төрөл зориулалтаар нь ангилан 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулан бүртгэх албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант оны 5 дугаар сард Ковид цар тахалын нөхцөл байдлаас шалтгаалан хичээл цахимаар орж байх үед 9 багшид 1,401,129 төгрөгийн илүү цагийг 12 дугаар анги төгсөж буй хүүхдүүдэд давтлага өгөхөөр олгосон. Илүү цаг олгосон анхан шатны баримт хангалтгүй, сургалтын менежерийн гаргасан сургалтын цагийн тооцоо гарын үсэггүй, илүү цаг олгох

захирлын тушаалгүй, Засгийн газрын 382 дугаар тогтоолын нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг хавсаргаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", ЗГ-ын 382 дугаар тогтоолын хавсралт 2-ын 3 дах заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү цагийн хөлс олгохдоо эрх бүхий байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг хэрэгжүүлэн анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангуулж байх талаар албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урсгал зардал

1.1. Илрүүлэлт:

Төсвийн жил дуусахын өмнө 12 дугаар сарын 21-ны өдөр 210401-Бичиг хэргээс 661.0 мянга, 210404-ном хэвлэлээс 708.9 мянга, 210406-БҮТЭЗ-ээс 2,315.2 мянга, 210901-бараа үйлчилгээний бусад зардлаас 988.0 мянга, 210503-Зөөлөн эдлэлээс 519.5 мянга, 210902-Хичээл практикаас 1,560.6 мянга төгрөг нийт 6,752.7 мянган төгрөгийн зардлыг зарцуулж Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" гэж заасныг мөрдөөгүйтэй холбоотой байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн зарцуулалтад үр дүнтэй хяналт хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	15 дугаар сургууль	4	14,899.5	1	1,079.7			2	7,067.1	1	6,752.7